



**НИЙСЛЭЛИЙН  
ТӨР ЗАХИРГААНЫ АВТО БААЗ УТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 02 сарын 11 өдөр

Дугаар A/16

Улаанбаатар хот

**Нэг хот - Нэг стандарт зорилтот жилийн  
төлөвлөгөө батлах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн "Нэг хот-Нэг стандарт" A/01 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2020 оны A/01 дүгээр захирамжаар 2020 оныг "Нэг хот-Нэг стандарт" жил болгосонтой холбоотойгоор зорилтот жилийн хүрээнд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталсугай.

2. Зорилтот жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллахыг хэлтсийн дарга нарт, төсвийг байгууллагын жилийн бизнес төлөвлөгөөнд тусган ажиллахыг Санхүү, төлөвлөлтийн хэлтэс /Х.Одончимэг/-т тус тус даалгасугай.

ДАРГА



Ш.НАРАНБААТАР




БАТЛАВ  
 НИЙСЛЭЛИЙН ТӨР ЗАХИРГААНЫ АВТО БААЗ  
 УТУГ-ЫН ДАРГА   
 Ц.НАРАНБААТАР  
 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдөр  
 1119279037 - 2117169

2020 ОНД "НЭГ ХОТ-НЭГ СТАНДАРТ" ЗОРИЛТОТ ЖИЛИЙН ХҮРЭЭНД НИЙСЛЭЛИЙН ТӨР ЗАХИРГААНЫ  
 АВТО БААЗ УТУГ-ААС ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/Д	2020 онд хийж, хэрэгжүүлэх ажил	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүн	Төсөв /мян.төг/	Хэрэгжүүлэх /хэлтэс/	Хугацаа
1	Нийслэлийн Засаг даргын А/01 захирамжийн дагуу "Нэг хот-Нэг стандарт" зорилтот жилийн хүрээнд хийх ажлыг үйлчлүүлэгч байгууллагаар дүгнүүлэх. (вэб сайтаар санал асуулга авна.)	Сэтгэл ханамжийн судалгааг байгууллагын цахим /www.baaz.ub.gov.mn/ хаягаар авна.	Байгууллагын үйл ажиллагааг доголдолгүй хэвийн явуулна.	Төсөв шаардахгүй	Авто бааз /Бүх хэлтэс/	II, IV улирал
2	Автомашин худалдан авах ажиллагааг зохион байгуулна.	2020 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 93 сая төгрөгийг Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар тендер зохион байгуулна.	Байгууллагын үйл ажиллагааг доголдолгүй хэвийн явуулна.	93,0	Авто бааз /Бүх хэлтэс/	жилдээ



3	Байгууллагын гадна фасадын засвар үйлчилгээг хийж гүйцэтгэнэ.	2020 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Нийслэлийн төсвөөс 315 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тохижуулна.	Албан хаагчид сэтгэл ханамжтай, аюулгүй ажил үүргээ гүйцэтгэж ажиллана.	315,0	Авто бааз /Бүх хэлтэс/	жилдээ
4	Автомашинны засвар үйлчилгээний тоног төхөөрөмжийг стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.	2020 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Нийслэлийн төсвөөс 92 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тохижуулна.	Байгууллагын үйл ажиллагааг доголдолгүй хэвийн явуулна.	92,0	Авто бааз /ТЗХ, СТХ хэлтэс/	жилдээ
5	Авто тээврийн хэрэгслийн техникийн бэлэн байдал, стандарт нормыг мөрдөн ажиллах талаар ажил зохион байгуулна.	Шинэчлэгдсэн стандарт нормуудыг татан авч жолооч ажилчдад танилцуулга сургалт явуулна.	Байгууллагын үйл ажиллагааг доголдолгүй хэвийн явуулна.	Төсөв шаардахгүй	Авто бааз /ТЗХ хэлтэс/	жилдээ
6	Үйлчилгээнд явж байгаа авто тээврийн хэрэгслийн өнгө үзэмж, жолооч нарын хувцаслалтын стандарт, соёлч боловсон шуурхай, чирэгдэлгүй үйлчлэх байдалд хяналт тавьж улирал тутамд шалгалт явуулна.	Улирлын эхэнд сар бүр жишиг шалгалтыг уламжлал болгон зохион байгуулж, жолооч ажилчдыг нормын дүрэмт хувцасаар хангаж жигдрүүлнэ.	Нэг хот нэг стандарт зорилтын хүрээнд жолооч нарыг стандарт хувцастай болгоно.	6,0	Авто бааз /Бүх хэлтэс/	жилдээ

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:  
 ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН  
 ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ, ТОГТООЛ, ЗАХИРАМЖИЙН  
 ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН  О.ХАЛИУН